



НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТУХАЙ
МОНГОЛ УЛС
БОЛОН
БҮГД НАЙРАМДАХ ПОЛЬШ УЛС ХООРОНДЫН
ХЭЛЭЛЦЭЭР

Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Польш Улс (Цаашид “Хэлэлцэн тохиролцогч талууд” гэх) хоорондын хэлэлцээрээр дараахь зүйлийг харилцан тохиролцов. Үүнд:

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Ерөнхий заалт

1 дүгээр зүйл

Нэр томъёо

1. Энэхүү хэлэлцээрийн хүрээнд:

(1) “Хууль тогтоомж” гэж энэхүү хэлэлцээрийн 2 дугаар зүйлд заасан нийгмийн хамгааллын салбарын хууль болон бусад холбогдох эрх зүйн актыг хэлнэ.

(2) “Эрх бүхий этгээд” гэж

1) Монгол Улсын тухайд нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн сайд,(яам)-ыг;

2) Бүгд Найрамдах Польш Улсын тухайд нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн сайдыг тус тус хэлнэ.

(3) “Эрх бүхий байгууллага” гэж энэхүү хэлэлцээрт хамаарч буй хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үүрэг бүхий байгууллагыг хэлнэ.

(4) “Харилцагч байгууллага” гэж энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлэх зорилгоор Хэлэлцэн тохиролцогч талуудын байгууллага хоорондын харилцааг удирдан зохион байгуулах, мэдээлэл солилцоог хангах үүрэг бүхий байгууллагыг хэлнэ.

(5) “Оршин суух газар” гэж Хэлэлцэн тохиролцогч талуудын холбогдох хууль тогтоомжийн дагуу байнга оршин суудаг газрыг хэлнэ.

(6) “Түр оршин суух газар” гэж түр оршин суух газрыг хэлнэ.

(7) “Даатгуулсан хугацаа” гэж Хэлэлцэн тохиролцогч талуудын хууль тогтоомжийн дагуу хөдөлмөр эрхэлж, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацаа болон шимтгэл төлснөөр тооцох хугацааг хэлнэ.

(8) “Даатгуулагч” гэж Хэлэлцэн тохиролцогч талуудын хууль тогтоомжийн дагуу нийгмийн даатгалд хамрагдсан эсхүл хамрагдаж буй иргэдийг хэлнэ.

(9) “Тэтгэвэр, тэтгэмж” гэж Хэлэлцэн тохиролцогч талуудын холбогдох хууль тогтоомжийн дагуу олгох тэтгэвэр болон бусад мөнгөн тэтгэмж, түүнчлэн тэдгээрийн нэмэлт болон нэмэгдлүүдийг хэлнэ.

2. Энэхүү хэлэлцээрт хэрэглэгдэж байгаа бусад нэр томъёог Хэлэлцэн тохиролцогч талуудын холбогдох хууль тогтоомжид заасан утгаар ойлгоно.

2 дугаар зүйл Хамрах хүрээ

1. Энэхүү хэлэлцээрт:

(1) Монгол Улсын тухайд Нийгмийн даатгалын тухай хуулийн дагуу даатгуулагчид олгох дараахь тэтгэвэр, тэтгэмж хамаарна. Үүнд:

- 1) Тэтгэврийн даатгалын сангаас олгох өндөр насны, тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны тэтгэвэр;
- 2) Тэтгэмжийн даатгалын сангаас олгох хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны, оршуулгын тэтгэмж;
- 3) Ажилгүйдлийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмж;
- 4) Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж;

(2) Бүгд Найрамдах Польш Улсын тухайд нийгмийн хамгааллын дараахь тэтгэвэр, тэтгэмжийн төрөл хамаарна. Үүнд:

- 1) Ажилгүйдлийн тэтгэмж (тариачдын нийгмийн даатгал болон нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмж);
- 2) Хөдөлмөрийн чадвар түр алдсаны болон жирэмсний, амаржсаны тэтгэмж;
- 3) Өндөр насны тэтгэвэр, хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр болон тэжээгчээ алдсаны тэтгэвэр;
- 4) Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэмж,
- 5) Оршуулгын тэтгэмж;

2. Хууль тогтоомжид оруулсан нэмэлт, өөрчлөлт болон шинэчилсэн хууль тогтоомжууд энэхүү хэлэлцээрт нэгэн адил хамаарна.

3. Хэлэлцэн тохиролцогч нэг талын хууль тогтоомжид тэтгэвэр, тэтгэмжийн шинэ төрөл нэмсэн нэмэлт, өөрчлөлт орсон бол тухайн талын эрх бүхий этгээд нь Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын эрх бүхий этгээдэд энэхүү өөрчлөлтийг 6 сарын дотор хэлэлцээрт хамаарахгүй гэж мэдэгдсэн тохиолдолд тухайн нэмэлт, өөрчлөлт энэхүү хэлэлцээрт хамаарахгүй.

3 дугаар зүйл Хэлэлцээрт хамрагдах этгээд

Энэхүү хэлэлцээрт:

(1) Хэлэлцэн тохиролцогч нэг талын болон хоёр талын хууль тогтоомжид хамрагдаж байгаа, хамрагдаж байсан аливаа иргэн;

(2) Энэхүү зүйлийн 1 дэх заалтад заасан этгээдээс эрх шилжүүлэн авсан этгээд хамаарна.

4 дүгээр зүйл

Эрх тэгш хандах зарчим

Энэхүү хэлэлцээрт өөрөөр заагаагүй бол хэлэлцээрт хамаарах аливаа этгээд Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын хууль тогтоомжийн дагуу тухайн улсын иргэний эдлэх эрхийг эдэлж, үүргийг нэгэн адил хүлээнэ.

5 дугаар зүйл

Тэтгэврийг гадаадад шилжүүлэх

1. Энэхүү хэлэлцээрт өөрөөр заагаагүй бол Хэлэлцэн тохиролцогч нэг талын хууль тогтоомжийн дагуу тогтоосон тэтгэврийг тухайн этгээд Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын нутаг дэвсгэрт оршин суудаг гэсэн үндэслэлээр бууруулах, өөрчлөх, түр зогсоох, цуцлахыг үл зөвшөөрнө.

2. Энэхүү зүйлийн 1 дэх заалт нь дараахь тэтгэмжид үйлчлэхгүй. Үүнд:

(1) Монгол Улсын тухайд Хөдөлмөрийн чадвар түр алдсаны, Жирэмсний болон амаржсаны, Ажилгүйдлийн тэтгэмж, Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох тэтгэмж;

(2) Бүгд Найрамдах Польш Улсын тухайд ажилгүйдлийн тэтгэмж, хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны тэтгэмж, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох тэтгэмж, тусгай нөхцөлөөр олгох тэтгэмж болон онцгой тохиолдлууд.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Хэрэглэгдэх хууль тогтоомж

6 дугаар зүйл

Ерөнхий заалт

Энэхүү хэлэлцээрийн 7, 8 дугаар зүйлд өөрөөр заагаагүй бол:

(1) Хэлэлцэн тохиролцогч нэг талын нутаг дэвсгэрт хөдөлмөр эрхэлж буй этгээд нь эрхэлж буй хөдөлмөрийнхөө хувьд тухайн Хэлэлцэн

тохиролцогч талын хууль тогтоомжийг дагаж мөрдөнө;

(2) Хэлэлцэн тохиролцогч нэг талын нутаг дэвсгэрт хувиараа хөдөлмөр эрхлэгчид нь эрхэлж буй хөдөлмөрийнхөө хувьд тухайн Хэлэлцэн тохиролцогч талын хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.

7 дугаар зүйл **Тусгай заалтууд**

1. Хэлэлцэн тохиролцогч нэг талын нутаг дэвсгэрт бүртгэлтэй ажил олгогчоос Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын нутаг дэвсгэрт 60-аас илүүгүй сарын хугацаанд ажиллахаар томилогдсон ажилтанд Хэлэлцэн тохиролцогч эхний талын хууль тогтоомж үйлчилнэ.

2. Энэхүү зүйлийн 1 дэх заалт нь Хэлэлцэн тохиролцогч аль нэг талын нутаг дэвсгэрт бүртгэлтэй ажил олгогчоос гуравдагч орны нутаг дэвсгэрт ажиллахаар томилогдсон ажилтан үргэлжлүүлэн Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын нутаг дэвсгэр дээр ажиллахаар томилогдож буй тохиолдолд мөн адил үйлчилнэ.

3. Хэлэлцэн тохиролцогч нэг талын нутаг дэвсгэрт бүртгэлтэй, олон улсын зорчигч болон бараа тээврийн үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгжид ажилладаг этгээд тухайн компанийн бүртгэлтэй Хэлэлцэн тохиролцогч талын хууль тогтоомжийг мөрдөнө.

4. Хэлэлцэн тохиролцогч талын далбааг мандуулсан хөлөг онгоц дээр ажиллаж буй ажилтан тухайн Хэлэлцэн тохиролцогч талын хууль тогтоомжид хамаарна. Харин хөлөг онгоц дээр ажиллаж буй хүн Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын нутаг дэвсгэрт байрладаг байгууллагаас эсхүл тухайн талын нутаг дэвсгэрт оршин сууж буй этгээдээс цалинждаг бол тухайн Хэлэлцэн тохиролцогч талын хууль тогтоомжид хамаарна. Гуравдагч орны далбааг мандуулсан хөлөг онгоц дээр ажилладаг боловч Хэлэлцэн тохиролцогч нэг талын нутаг дэвсгэрт байрладаг байгууллага юмуу тухайн талын нутаг дэвсгэрт оршин сууж буй этгээдээс цалинждаг тохиолдолд энэ заалтын хоёр дахь өгүүлбэр мөн адил үйлчилнэ.

5. Төрийн албан хаагч болон тэдгээртэй адилтгах этгээд нь ажил олгогч байгууллагыг харьяалах Хэлэлцэн тохиролцогч талын хууль тогтоомжийг мөрдөнө.

6. Дипломат болон консулын төлөөлөгчийн газрын албан хаагчид 1961 оны

4-р сарын 18-ны өдрийн Дипломат харилцааны тухай Венийн конвенц болон 1963 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн Консулын харилцааны тухай Венийн конвенцийг мөрдөнө.

8 дугаар зүйл
Онцгой тохиолдол

Хэлэлцэн тохиролцогч талуудын эрх бүхий этгээд болон тэдний томилсон байгууллагууд харилцан тохиролцсоны үндсэн дээр тухайн хувь хүн, хүмүүсийн ашиг сонирхолыг харгалзан энэхүү хэлэлцээрийн 6 дугаар зүйл болон 7 дугаар зүйлийн 1-5 дахь заалтын үйлчлэлээс чөлөөлж болно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ
Тэтгэвэр, тэтгэмжийн талаарх заалт

1 дүгээр хэсэг
Ажилгүйдлийн тэтгэмж

9 дүгээр зүйл
Тэтгэвэр, тэтгэмж олгох эрхийг тодорхойлох

1. Тухайн иргэн ажилгүй болохынхоо өмнө нийгмийн даатгалын шимтгэл төлж байсан Хэлэлцэн тохиролцогч талын хууль тогтоомжийн дагуу ажилгүйдлийн тэтгэмж авах эрхийг тодорхойлохдоо шаардлагатай гэж үзвэл Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын хууль тогтоомжийн дагуу нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг харгалзан үзнэ.

2. Хэлэлцэн тохиролцогч нэг талд ажилгүйдлийн тэтгэмж авахаар өргөдөл мэдүүлснээс өмнөх 12 сарын хугацаанд Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын нутаг дэвсгэр дээр ажилгүйдлийн тэтгэмж авч байсан бол Хэлэлцэн тохиролцогч эхний тал тухайн хугацааг хассан хугацаагаар тэтгэмж олгоно.

2 дугаар хэсэг
Хөдөлмөрийн чадвараа түр алдсаны
болон жирэмсний, амаржсаны тэтгэмж

10 дугаар зүйл
Даатгалын шимтгэл төлсөн хугацааг нэгтгэж тооцох

Тухайн этгээдийн тэтгэмж авах эрхийг тодорхойлохдоо Хэлэлцэн

тохиролцогч хоёр талд хоёуланд нь шимтгэл төлсөн давхцаагүй хугацааг харгалзан үзнэ.

11 дүгээр зүйл
Тэтгэмж олголт

Хэлэлцэн тохиролцогч тал нь өөрийн хууль тогтоомжийн дагуу тухайн нутаг дэвсгэрт даатгуулсан этгээдэд хөдөлмөрийн чадвараа түр алдсаны, жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг олгоно.

3 дугаар хэсэг
Тэтгэвэр тооцох

12 дугаар зүйл
Даатгалын шимтгэл төлсөн хугацааг нэгтгэж тооцох

1. Хэлэлцэн тохиролцогч нэг талын хууль тогтоомжийн дагуу тодорхой шимтгэл төлсөн хугацааг үндэслэн тэтгэвэр тогтоох, эрхийг хадгалах, дахин сэргээдэг бол тухайн талын эрх бүхий байгууллага нь Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын хууль, тогтоомжийн дагуу шимтгэл төлсөн давхцаагүй хугацааг өөрийн талын хууль тогтоомжийн дагуу шимтгэл төлсөнтэй нэгэн адилаар тооцон үзнэ.
2. Хэлэлцэн тохиролцогч нэг талын хууль тогтоомжийн дагуу хөдөлмөрийн тусгай нөхцөл, ажил мэргэжил, юмуу тусгай схемийн дагуу шимтгэл төлсөн хугацааг харгалзан тэтгэвэр тогтоодог бол Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын хууль тогтоомжийн дагуу тухайн ажил мэргэжил, хөдөлмөрийн эрхэлж төлсөн хугацаа нь ижил схемд хамрагддаг бол тухайн схемийн дагуу, хамрагддаггүй бол энгийн схемд ажилласнаар тухайн этгээдийг тэтгэврийг тогтоохдоо нэгтгэн тооцно.
3. Хэрэв энэ зүйлийн 1 дэх заалтын дагуу даатгалын шимтгэл төлсөн хугацааг нэгтгэн тооцсоны дараа тэтгэвэр авах эрх үүсэхгүй тохиолдолд тэтгэвэр тогтоож буй талын эрх бүхий байгууллага нь шимтгэл төлсөн хугацааг нэгтгэн тооцох асуудлаар Хэлэлцэн тохиролцогч хоёр талтай хэлэлцээр байгуулсан Гуравдагч талд шимтгэл төлсөн хугацааг харгалзан үзнэ.

13 дугаар зүйл
12 сараас доош хугацаагаар төлсөн шимтгэл

1. Хэрэв Хэлэлцэн тохиролцогч нэг талын хууль тогтоомжоор шимтгэл төлсөн хугацаа нь 12 сар хүрэхгүй бөгөөд тэтгэвэр авах эрх үүсэхээргүй тохиолдолд тухайн Хэлэлцэн тохиролцогч талын эрх бүхий байгууллага тэтгэвэр олгохгүй.

2. Энэ зүйлийн 1 дэх заалтыг үл хамааран Хэлэлцэн тохиролцогч аль аль талын хууль тогтоомжийн дагуу 12 сараас доош хугацаанд шимтгэл төлсөн бөгөөд эдгээр хугацааг нэгтгэн тооцсоноор тэтгэвэр, тэтгэмж авах эрх үүсч байвал тухайн Хэлэлцэн тохиролцогч талын эрх бүхий байгууллага шимтгэл төлсөн хугацааг нэгтгэн тооцох асуудлыг авч үзнэ.

14 дүгээр зүйл
Үйл явдлыг адилтгах

Хэлэлцэн тохиролцогч нэг талын нутаг дэвсгэрт тэтгэвэр авах эрх үүсэх, тэтгэврийг бууруулах, түр зогсоход болон тэтгэврийн хэмжээнд хууль, эрх зүйн нөлөө үзүүлэх үйл явдал тохиолдвол тэдгээрийг Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын нутаг дэвсгэрт болсон мэтээр адилтган үзнэ.

15 дугаар зүйл
**Даатгалын шимтгэл төлсөн хугацааг нэгтгэн
тооцохгүйгээр тэтгэвэр тогтоох**

Хэлэлцэн тохиролцогч аль нэг талд даатгалын шимтгэл төлсөн хугацааг тооцолгүйгээр Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын нутаг дэвсгэрт тэтгэвэр авах эрх үүссэн тохиолдолд тэтгэвэр авах эрх үүссэн талын эрх бүхий байгууллага өөрийн орны хууль тогтоомжийн дагуу тухайн орны нутаг дэвсгэр дээр даатгалын шимтгэл төлсөн хугацааг үндэслэн тэтгэврийг тогтооно.

16 дугаар зүйл
**Даатгалын шимтгэл төлсөн хугацааг нэгтгэн
тооцож тэтгэвэр тогтоох**

1. Хэлэлцэн тохиролцогч аль нэг талын хууль тогтоомж болон энэхүү хэлэлцээрийн 12 дугаар зүйлийг харгалзан тухайн этгээдийн тэтгэвэр авах

эрх үүсэж байгаа бол тэтгэвэр тогтоож буй талын эрх бүхий байгууллага нь дараахь байдлаар тэтгэврийг тогтооно. Үүнд:

(1) Шимтгэл төлсөн бүх хугацааг өөрийн орны хууль тогтоомжийн дагуу төлсөн мэтээр үзэн бодит тэтгэвэр тогтооход ашиглах онолын хэмжээг тогтоох;

(2) Энэ зүйлийн 1.1 дэх заалтад дурдсан онолын хэмжээнд тулгуурлан шимтгэл төлсөн бүх хугацаанаас өөрийн орны хууль тогтоомжийн дагуу шимтгэл төлсөн хугацаанд харгалзах бодит тэтгэврийг хувиалан тооцно.

2. Тэтгэвэр бодох суурь цалинг тодорхойлохдоо, Хэлэлцэн тохиролцогч талуудын эрх бүхий байгууллагууд зөвхөн өөрийн орны хууль тогтоомжийн дагуу олгосон цалин хөлс, төлсөн шимтгэлийг харгалзан үзнэ.

4 дүгээр хэсэг

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин

17 дугаар зүйл

Тэтгэвэр авах эрх үүсэх

1. Ажлын байрны осол болон мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэврийг олгохдоо тухайн ажлын байрны осолд орсон болон мэргэжлээс шалтгаалсан өвчнийг үүсгэх ажлыг хийж байсан талын хууль тогтоомжийн дагуу тогтооно.

2. Хэлэлцэн тохиролцогч нэг талын хууль тогтоомжийн дагуу мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр олгохдоо уг өвчин тухайн улсын нутаг дэвсгэр дээр анх оношилогдсон байх шаардлагатай байтал Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын нутаг дэвсгэр дээр өвчнийг оношилсон бол эхний талын нутаг дэвсгэр дээр өвчнийг оношилсонтой адилтган үзнэ.

3. Хэлэлцэн тохиролцогч нэг талын хууль тогтоомжийн дагуу мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр олгохдоо даатгуулагч нь тухайн мэргэжлийн ажлыг зохих хугацааны турш хийсэн байхыг шаарддаг бол Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын нутаг дэвсгэр дээр адил төрлийн ажил эрхэлж байсан хугацааг мөн харгалзан үзнэ.

18 дугаар зүйл

Мэргэжлээс шалтгаалсан өвчин хүндэрсэн тохиолдол

1. Хэлэлцэн тохиролцогч нэг талын хууль тогтоомжийн дагуу мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр авах эрх нь үүссэн этгээд Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын нутаг дэвсгэрт мэргэжлээс шалтгаалах өвчнийг нь хүндрүүлэхээргүй ажил хөдөлмөр эрхлэн, даатгалд хамрагдаж байх үед уг өвчин сэдэрсэн бол Хэлэлцэн тохиролцогч эхний талын эрх бүхий байгууллага тэтгэврийг бүрэн олгоно.

2. Хэлэлцэн тохиролцогч нэг талын нутаг дэвсгэр дээр тухайн орны хууль тогтоомжийн дагуу мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр тогтоолгосон даатгуулагч Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын нутаг дэвсгэр дээр өвчнөө сэдэрээж болзошгүй ажил эрхэлж байгаа тохиолдолд:

(1) Мэргэжлээс шалтгаалсан өвчин хүндэрсэн эсэхийг үл хамааран Хэлэлцэн тохиролцогч эхний тал тэтгэврийг үргэлжлүүлэн олгоно;

(2) Тухайн даатгуулагч нутаг дэвсгэр дээр нь мэргэжлээс шалтгаалсан өвчнийг хүндрүүлж болзошгүй ажил эрхэлж байсан тохиолдолд Хэлэлцэн тохиролцогч тал өвчин хүндрэхээс өмнө тогтоосон тэтгэвэр болон өвчин хүндэрсний дараа авбал зохих тэтгэврийн зөрүүг нутаг дэвсгэр дээр нь хөдөлмөр эрхэлж байсан Хэлэлцэн тохиролцогч тал олгоно.

5 дугаар хэсэг

Оршуулгын тэтгэмж

19 дүгээр зүйл

Тэтгэмж авах үндэслэл

1. Ажилтан, хувиараа хөдөлмөр эрхлэгч, тэтгэвэр авагч нас барах үед хууль тогтоомж нь үйлчилж байсан Хэлэлцэн тохиролцогч талын эрх бүхий байгууллага оршуулгын тэтгэмжийг тогтооно.

2. Энэ зүйлийн 1 дэх заалтад заасан оршуулгын тэтгэмжийг олгох эрх нь Хэлэлцэн тохиролцогч талын хууль тогтоомжийн дагуу шимтгэл төлсөн хугацаанаас хамаарах бол хэлэлцээрийн 10 дугаар зүйлд заасны дагуу шийдвэрлэнэ.

3. Хэлэлцэн тохиролцогч хоёр талын хууль тогтоомжийн дагуу тэтгэвэр авч

байсан этгээд нас барж, Хэлэлцэн тохиролцогч хоёр талын хууль тогтоомжийн дагуу оршуулгын тэтгэмж авах эрх үүссэн тохиолдолд тухайн этгээд нутаг дэвсгэр дээр нь нас барсан Хэлэлцэн тохиролцогч талын эрх бүхий байгууллага тэтгэмж авах эрхийг тодорхойлно.

4. Энэ зүйлийн 3 дахь заалтад заасан этгээд Хэлэлцэн тохиролцогч хоёр талын нутаг дэвсгэр дээр нас бараагүй бол тухайн этгээд хамгийн сүүлд даатгалын шимтгэл төлсөн талын эрх бүхий байгууллага тэтгэмж авах эрхийг тодорхойлно.

5. Энэ зүйлийн 1-4 дэх заалт энэхүү хэлэлцээрийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалтад заасан этгээдэд мөн адил үйлчилнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Бусад заалт

20 дугаар зүйл

Эрх бүхий этгээдийн эрх мэдлийн хүрээ

Энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан эрх бүхий этгээд дараахь эрхийг эдэлнэ. Үүнд:

(1) Энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай арга хэмжээг тусгасан удирдлагын тохиролцоог байгуулна;

(2) Энэхүү хэлэлцээрийн зохицуулалтыг хэрэгжүүлэх, эрчимжүүлэх үүднээс харилцагч болон эрх бүхий байгууллагыг томилно;

(3) Талуудын хууль тогтоомжид энэхүү хэлэлцээрийн хэрэгжилтэд нөлөөлж болзошгүй өөрчлөлт орвол энэ тухай мэдээллийг харилцан солилцоно.

21 дүгээр зүйл

Удирдлагын ба эрх зүйн хамтын ажиллагаа

1. Хэлэлцэн тохиролцогч талуудын эрх бүхий этгээд, харилцагч болон эрх бүхий байгууллага нь энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлэх зорилгоор харилцан туслалцаа үзүүлнэ. Эрх бүхий этгээдүүд тодорхой зардлыг буцаан олгуулахаар заагаагүй бол энэхүү зүйлд заасан туслалцааг харилцан үнэ төлбөргүй үзүүлнэ.

2. Хэлэлцэн тохиролцогч нэг талын эрх бүхий этгээд, харилцагч болон эрх

бүхий байгууллагаас олгосон баримт бичгийг Хэлэлцэн тохиролцогч нөгөө тал хүлээн зөвшөөрнө.

22 дугаар зүйл **Мэдээллийн нууцыг хамгаалах тухай**

1. Хувь хүнийг тодорхойлох боломжтой аливаа мэдээлэл нь хувь хүний мэдээллийг бүрдүүлдэг бөгөөд уг мэдээллийн нууцлалыг хамгаална.

2 Хэлэлцэн тохиролцогч талуудын эрх бүхий этгээдүүд, харилцагч болон эрх бүхий байгууллагууд энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хувь хүний талаарх шаардлагатай бүх мэдээллийг солилцож болно.

3. Хэлэлцэн тохиролцогч талууд харилцан солилцсон хувь хүний мэдээллийг зөвхөн хэлэлцээрийг хэрэгжүүлэх зорилгоор ашиглана.

4. Хэлэлцэн тохиролцогч тал хэлэлцээрийг хэрэгжүүлэхээс бусад зорилгоор дараахь нөхцөлд тухайн хүний зөвшөөрөлтэй, эсхүл зөвшөөрөлгүйгээр хувь хүний мэдээллийг ашиглах боломжтой. Үүнд:

(1) Мэдээллийг анх хүлээн авсан зорилготой шууд хамаарал бүхий асуудалд хэрэглэх тохиолдолд;

(2) Тухайн хүний эрх ашгийн төлөө хэрэглэх илт шаардлага бий бол;

(3) Монгол Улсын болон Бүгд Найрамдах Польш Улсын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай тохиолдолд.

5. Энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Хэлэлцэн тохиролцогч нэг талын эрх бүхий этгээд, харилцагч болон эрх бүхий байгууллагад хувь хүний мэдээллийг шилжүүлсэн бол тухайн эрх бүхий этгээд болон байгууллагууд өөрийн орны ямар нэгэн байгууллагад зөвхөн хэлэлцээрийг хэрэгжүүлэх зорилгоор хувь хүний мэдээллийг дамжуулна.

6. Хэлэлцэн тохиролцогч талууд дараахь нөхцөлд тухайн хүний зөвшөөрөлтэй, эсхүл зөвшөөрөлгүйгээр хувь хүний мэдээллийг шилжүүлэх боломжтой:

(1) Хэлэлцэн тохиролцогч аль нэг талын холбогдох байгууллага эрх мэдлээ хэрэгжүүлэхэд тухайн хувь хүний мэдээлэл зайлшгүй хэрэгцээтэй тохиолдолд;

(2) Тухайн хүний эрх ашгийн төлөө хэрэглэх илт шаардлага бий бол;

(3) Монгол Улсын болон Бүгд Найрамдах Польш Улсын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай тохиолдолд.

7. Энэ зүйлийн 3 дахь заалтын дагуу мэдээллийг шилжүүлэхдээ Хэлэлцэн тохиролцогч хоёр талын эрх бүхий этгээд, харилцагч болон эрх бүхий байгууллагууд нь тухайн мэдээллийн нууцлалыг хамгаалах арга хэмжээ авахаа харилцан батална.

8. Энэ зүйлийн 3 дахь заалтын дагуу мэдээллийг хүлээн авсан Хэлэлцэн тохиролцогч Талын эрх бүхий этгээд, харилцагч болон эрх бүхий байгууллагууд нь хувийн мэдээлэлд зөвшөөрөлгүй нэвтрэх, түүнийг хууль бусаар өөрчлөх, зөвшөөрөлгүйгээр задруулах зэргээс хамгаалах арга хэмжээ авна.

9. Энэ зүйлийн 3 дахь заалтын дагуу хувийн мэдээлэл хүлээн авсан Хэлэлцэн тохиролцогч талын эрх бүхий этгээд, харилцагч болон эрх бүхий байгууллага нь мэдээлэл хүлээн авсан зорилгын дагуу мэдээллийг бүрэн, зөв шинэчлэх арга хэмжээ авна. Шаардлагатай тохиолдолд буруу мэдээллийг залруулах, хууль бусаар дамжуулсан мэдээллийг устгах арга хэмжээ авна. Мэдээллийг дамжуулсан Хэлэлцэн тохиролцогч талын хууль тогтоомжийн дагуу задруулахыг хориглосон мэдээллийг шилжүүлсэн бол тухайн талын хүсэлтээр мэдээллийг устгана.

10. Энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлэх зорилгоор хууль тогтоомжийн дагуу хүлээн авсан хувь хүний мэдээллийг үр ашигтай ашиглаж зорилгодоо хүрсэн бол нэн даруй тухайн мэдээллийг устгана. Хэлэлцэн тохиролцогч хоёр талын эрх бүхий этгээдүүд, харилцагч болон эрх бүхий байгууллагууд мэдээллийг аюулгүй, бүрэн устгах арга хэмжээ авах болон устгавал зохих мэдээллийн хамгааллыг харилцан хангана.

11. Хэлэлцэн тохиролцогч аль нэг талын эрх бүхий этгээд, харилцагч болон эрх бүхий байгууллагуудын хүсэлтийг үндэслэн тухайн хүнд энэ зүйлийн 3 дахь заалтад дурдсан мэдээллийг шилжүүлсэн тухай болон мэдээллийг энэхүү хэлэлцээрийн зорилгоос гадуур ашигласан тухай мэдээлэл авах эрхтэй. Өөрийнх нь хувийн мэдээлэл нутаг дэвсгэр дээр нь хадгалагдаж байгаа Хэлэлцэн тохиролцогч талын хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол тухайн хүн хувийн мэдээллээ үзэх болон засварлах эрхтэй.

12. Хувийн мэдээллийн нууцыг хамгаалах тухай хууль тогтоомжид өөрчлөлт орсон тохиолдолд Хэлэлцэн тохиролцогч талуудын эрх бүхий этгээдүүд нэн даруй бие биендээ мэдэгдэнэ.

13. Энэ зүйлийн 3 дахь заалт нь энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлэх зорилгоор, эсхүл энэхүү хэлэлцээртэй холбогдуулан цуглуулсан бусад мэдээлэлд мөн адил үйлчилнэ.

23 дугаар зүйл

Хураамж ба баримт бичгийн баталгаажуулалтаас чөлөөлөх

1. Аливаа баримт бичгийг төлбөр, хураамжаас бүрэн, эсхүл хэсэгчлэн чөлөөлөхгүй гэж Хэлэлцэн тохиролцогч нэг талын хууль тогтоомжид заасан байвал, Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын хууль тогтоомжийн дагуу явуулсан ижил төрлийн баримт бичгүүдэд энэ заалт нэгэн адил хамаарна.

2. Энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлэх зорилгоор бүрдүүлэх аливаа өргөдөл, баримт бичиг, гэрчилгээнүүдийг дипломат болон консулын албанаас баталгаажуулах шаардлагагүй.

24 дүгээр зүйл

Баримт бичиг хүргүүлэх

1. Хэлэлцэн тохиролцогч нэг талын эрх бүхий этгээд, харилцагч болон эрх бүхий байгууллагад гаргасан өргөдөл, давж заалдах өргөдөл, мэдэгдлийг Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын эрх бүхий этгээд, харилцагч болон эрх бүхий байгууллагууд эхний Хэлэлцэн тохиролцогч талтай нэг өдөр хүлээн авснаар тооцно.

2. Өргөдөл гаргагч этгээд Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын хууль тогтоомжийн дагуу тэтгэвэр авах эрхээ хойшлуулах хүсэлт гаргаснаас бусад тохиолдолд Хэлэлцэн тохиролцогч нэг талын хууль тогтоомжийн дагуу тэтгэвэр тогтоолгохоор өргөдөл гаргасныг Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын хууль тогтоомжийн дагуу өргөдөл гаргасантай адилтган үзнэ.

25 дугаар зүйл
Эрүүл мэндийн үзлэг

1. Хэлэлцэн тохиролцогч нэг талын нутаг дэвсгэрт түр болон байнга оршин сууж байгаа хүнийг эрүүл мэндийн үзлэгт хамруулах шаардлагатай бол тухайн талын эрх бүхий байгууллага өөрийн зардлаар уг үзлэгийг хийлгэх арга хэмжээг авна.
2. Хэлэлцэн тохиролцогч хоёр талын байгууллагын хүсэлтээр эрүүл мэндийн үзлэг хийлгэсэн тохиолдолд уг үзлэгтэй холбогдон гарсан зардлыг нөхөн олгохгүй.

26 дугаар зүйл
Харилцах хэл

1. Энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлэхдээ Хэлэлцэн тохиролцогч хоёр талын эрх бүхий этгээдүүд, харилцагч болон эрх бүхий байгууллагууд нь Хэлэлцэн тохиролцогч хоёр талын албан ёсны, эсхүл англи хэлээр харилцана.
2. Хэлэлцэн тохиролцогч нэг Талын эрх бүхий этгээд буюу холбогдох байгууллага нь Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын өргөдөл, эсхүл баримт бичгийг нөгөө талын албан ёсны, эсхүл англи хэлээр үйлдсэн гэсэн шалтгаанаар хүлээн авахаас татгалзаж болохгүй.

27 дугаар зүйл
Тэтгэврийн төлбөрийг олгох

1. Энэхүү хэлэлцээрийн дагуу Хэлэлцэн тохиролцогч талуудын эрх бүхий этгээдүүд Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын нутаг дэвсгэр дээр оршин суугаа тэтгэвэр авагчид тэтгэврийг тухайн орны албан ёсны мөнгөн тэмдэгтээр, хэрэв тухайн орны албан ёсны мөнгөн тэмдэгт нь чөлөөтэй хөрвөх валют биш бол чөлөөтэй хөрвөх валютаар олгоно.
2. Хэлэлцэн тохиролцогч нэг тал нь валютын хяналт тогтоосны улмаас тухайн Хэлэлцэн тохиролцогч талын нутаг дэвсгэрээс гадна байгаа этгээдэд төлбөр, гуйвуулга, эсхүл мөнгөн сан, санхүүгийн хэрэгслийг шилжүүлэхэд хязгаарлагдмал нөхцөл байдал үүссэн тохиолдолд, тухайн Хэлэлцэн тохиролцогч тал нь энэхүү хэлэлцээрийн дагуу олговол зохих нийт төлбөрийг нөгөө улсын нутаг дэвсгэрт оршин суугаа 3 дугаар зүйлд

заасан этгээдэд шилжүүлэх арга хэмжээг нэн даруй авна.

28 дугаар зүйл
Маргаан шийдвэрлэх

Энэхүү хэлэлцээрийг тайлбарлах болон хэрэгжүүлэхтэй холбоотой аливаа маргааныг Хэлэлцэн тохиролцогч талуудын эрх бүхий этгээдүүд зөвлөлдөх замаар хамтран шийдвэрлэнэ.

ТАВДУГААР БҮЛЭГ
Шилжилтийн болон төгсгөлийн заалт

29 дүгээр зүйл
Шилжилтийн заалт

1. Энэхүү хэлэлцээрийн дагуу тус хэлэлцээрийг хүчин төгөлдөр болох өдрөөс өмнөх хугацаанд хамаарах тэтгэвэр олгох эрх үүсгэхгүй.

2. Энэхүү хэлэлцээрийн дагуу тэтгэвэр олгох эрхийг тодорхойлохдоо энэхүү хэлэлцээр хүчин төгөлдөр болох өдрөөс өмнө Хэлэлцэн тохиролцогч хоёр талын хууль тогтоомжийн дагуу даатгалын шимтгэл төлсөн хугацааг харгалзан үзнэ.

3. Энэхүү хэлэлцээр хүчин төгөлдөр болох өдрөөс өмнө үүссэн даатгалтай холбоотой үйл явдлыг өмнө нь эрх зүйн хувьд зохицуулах нөхцөл бүрдээгүй байсан гэсэн үндэслэлээр энэ зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг харгалзан уг хэлэлцээрийн хүрээнд зохицуулна.

4. Энэхүү хэлэлцээр хүчин төгөлдөр болохоос өмнө тогтоогдсон тэтгэвэрт зөвхөн энэхүү хэлэлцээрийн заалтуудын улмаас өөрчлөлт орохоор бол тухайн этгээдийн хүсэлтийг нь үндэслэн тэтгэврийг дахин тогтоож болно. Тэтгэвэр авах эрхийг ийнхүү дахин тогтоолгох нь тэтгэврийн өмнө тогтоосон хэмжээнээс бууруулах үндэслэл болохгүй.

30 дугаар зүйл
Хэлэлцээрийн үйлчлэх хугацаа

1. Энэхүү хэлэлцээр нь хязгааргүй хугацаанд хүчин төгөлдөр байна. Хэлэлцэн тохиролцогч аль нэг тал энэхүү хэлэлцээрийг цуцлах тухай хүсэлтээ хуанлийн жилийн эцсээс 6 сарын өмнө бичгээр мэдэгдэн

дуусгавар болгож болно. Энэ тохиолдолд энэхүү хэлэлцээр тухайн жил дуустал хүчин төгөлдөр мөрдөгдөж, цуцлагдана.

2. Энэхүү хэлэлцээр цуцлагдвал, тус хэлэлцээрийн дагуу тогтоогдсон бүх эрх хэвээр хадгалагдана.

3. Энэхүү хэлэлцээрийг цуцлагдах өдрөөс өмнө гаргасан өргөдлийг тус хэлэлцээрийн дагуу шийдвэрлэнэ.

31 дүгээр зүйл Хэлэлцээр хүчин төгөлдөр болох

Хэлэлцэн тохиролцогч талууд хэлэлцээр хүчин төгөлдөр болох дотоодын хууль тогтоомжийн шаардлагыг хангасан тухайгаа дипломат шугамаар бичгээр харилцан мэдэгдэнэ. Энэхүү хэлэлцээр нь хамгийн сүүлчийн мэдэгдлийг хүлээн авснаас хойших 3 дахь сарын эхний өдөр хүчин төгөлдөр болно.

Үүнийг гэрчилж, энэхүү хэлэлцээрт Хэлэлцэн тохиролцогч талуудын зохих эрх олгогдсон төлөөлөгчид гарын үсэг зурж баталгаажуулав.

Энэхүү хэлэлцээрийг 2018 оны 01 дугаар сарын 24-ны өдөр Вериаб хотноо монгол, польш, англи хэлээр тус бүр хоёр хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд адил хүчинтэй байна. Монгол, польш хэлээрх эхийг тайлбарлахад зөрүү гарвал англи эх бичвэрийг баримтална.

МОНГОЛ УЛСЫГ ТӨЛӨӨЛЖ:

БҮГД НАЙРАМДАХ ПОЛЬШ
УЛСЫГ ТӨЛӨӨЛЖ:




